



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2002 оны 8 сарын 05 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ**

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль"-ийн 16.2.2 заалт, "Эрүүл мэндийн тухай хууль"-ийн 12, 13 дугаар зүйл, Засгийн газрын 2002 оны 35 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2002 оны 138 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, комиссын дүрмийг хоёрдугаар, журмыг гуравдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн эмнэлгүүдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан төр, хувийн хэвшлийн зохистой харьцааг хангах, иргэдийн үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, хүн амын өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийж, бодит хэрэгцээнд тулгуурлан хувийн эмнэлгийн тусламж үзүүлэх бүх төрлийн үйлчилгээ эрхлэх асуудлыг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зөв байршуулан нэг цэгийн үйлчилгээний журмаар сард нэг удаа хуралдуулан тусгай зөвшөөрөл олгож байсугай.

Гурав. Комиссын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын жил бүрийн төсөвт суулган баталж өгч байхыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засаг, стратегийн бодлогын хэлтэс /М.Бат/-т даалгасугай.

Дөрөв. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан байгууллагуудын бүртгэл, жагсаалтыг дүүргийн эрүүл мэндийн нэгдлүүдэд тухай бүрд шилжүүлж, ажил үйлчилгээнд нь хяналт тавиулж, мэдээ тайланг нэгтгүүлэн авч байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Ц.Ганхүү/-т даалгасугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан 1999 оны А/117 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ *[Signature]* М.ЭНХБОЛД

0201210

353-р
 Нийслэлийн Засаг даргын 2002 оны
 захирамжийн нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ
 АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСТАЙ ЗӨВНӨӨРӨЛ ОЛГОХ
 НИЙСЛЭЛИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН**

Комиссын дарга:	Нийслэлийн Засаг даргын хөрөгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газрын дарга
Орлогч дарга:	Эрүүл мэндийн газрын эмнэлэг үйлчилгээний хэлтсийн дарга
Гишүүд:	Нийслэлийн Эрүүл мэндийн хяналтын албаны дарга Нийслэлийн эм хангамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Нийслэлийн ЭМГ-ын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дүн бүртгэлийн мэргэжилтэн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга Нийслэлийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга Нийслэлийн Нийгмийн даатгалын газрын Эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан тасгийн дарга
Нарийн бичгийн дарга	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын хувийн хэвсгийн Эрүүл мэндийн байгууллагын асуудал хариуцсан мэргэжилтэн

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ДҮРЭМ

- 1.1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох Нийслэлийн комисс (цаашид "Комисс" гэнэ) нь эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл (цаашид "тусгай зөвшөөрөл" гэх) олгох, бүртгэх, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг хяналт шийдвэрлэх үүрэгтэй ажиллана.
- 1.2. Комисс нь үйл ажиллагаандаа "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хууль", "Эрүүл мэндийн тухай хууль", "Эмийн тухай хууль"-нд тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг мөрдөнө.
- 1.3. Комисс нь сард 1 удаа тодорхой цагт хуралдаж, үйл ажиллагаа явуулах шаардлага хангасан хуулийн этгээд, иргэнд эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 1.4. Комисс нь 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Комисс нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд хурлыг комиссын дарга, түүний эзгүйд орлогч дарга удирдан гишүүдийн 80 %-ийн иргтэй хуралдуулж шийдвэрийг гишүүдийн олонхийн саналаар батлан гаргана.
- 1.5. Комисс шаардлагатай гэж үзвэл хэлэлцэх асуудлын хүрээнд комиссын хуралд Нийслэлийн сөрөнхий мэргэжилтнүүд болон шинжээч нарыг татан оролцуулна.
- 1.6. Комиссын нарийн бичгийн дарга хурал болохоос 3 хоногийн өмнө хэлэлцэх асуудалтай холбогдсон материалыг гишүүдэд тараах ба хурлыг зарыг 5 хоногийн дотор хүргэж, хурлын бэлтгэлийг хангуулж гишүүдийн иршигт бүрдүүлнэ.
- 1.7. Комиссын хурлын тэмдэглэл, шийдвэрийг дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгож, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комиссын тамга тэмдэг дарж баталгаажуулна.
- 1.8. Комиссын орлогч дарга нь комиссын хурал хуралдах хугаанаа, хэлэлцэх асуудлыг батлан хуралд бэлтгүүлнэ.
- 1.9. Тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага нь үйл ажиллагааны болон сарын шуурхай мэдээ тайлангаа дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн дүн бүртгэлд өгөх ба жилийн эцэст Эрүүл мэндийн газар нь нэгтгэж Эрүүл мэндийн яаманд хүргүүлнэ.
- 1.10. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдон гарсан маргааныг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий дээд шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

ХОЁР. КОМИССЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Комисс нь дор дурьдсан эрхийг эдэлнэ. Үүнд:
 - 2.1.1. Комисс нь эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг олгох, бүртгэх, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

- 2.1.2. Тусгай зөвшөөрөл бүхий эрүүл мэндийн байгууллагын талаар ирсэн мэдээлэл, өргөдөл, гомдлын эрүүл мэндийн хяналтын байгууллагаар шалгуулах
- 2.2. Комисс нь дор дурьдсан үүрэг хүлээнэ. Үүнд:
 - 2.2.1. Эпэхүү захирамжаар баталсан "Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох журам"-ыг мөрдлөг болгон ажиллах
 - 2.2.2. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй холбогдсон асуудлаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ БҮРТГЭХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

- 3.1.1. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг анх 1 жилийг хугацаагаар олгож, эрхийг гэрчилгээ олгож баталгаажуулна.
- 3.1.2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг тухайн байгууллагын үйл ажиллагааны тайлан, Эрүүл мэндийн улсын хяналтын албаны мэргэжлийн дүгнэлт, Татварын албаны тодорхойлолт, байрны баталгаажилтийг үндэслэн 3 хүртэл жилийн хугацаатай сунгана.
- 3.1.3. Зөвшөөрлийн гэрчилгээний сунгалт хийлгэлгүй ажилласал тохиолдолд зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан гэж үзэж хуулийн дагуу харпуулага тооцно.
- 3.1.4. Сунгалтыг хүчинтэй хугацаа дууссанаас хойш 1 сарын дотор хийж дуусгана.

Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

- 3.2.1. Тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.
- 3.2.2. Комисс нь түдгэлзүүлсэн шийдвэрийн талаар харъяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.
- 3.2.3. Тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллага тайлан мэдээг хугацаандаа өгөөгүй тохиолдолд зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ.

Тусгай зөвшөөрлийн сэргээх

- 3.3.1. Эмчилгээ үйлчилгээнд гарсан алдаа дутагдал нь нонтой гэж үзэх үндэслэлгүй бол
- 3.3.2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд
- 3.3.3. Эрүүл мэндийн байгууллага нь өөрчлөн байгуулагдсан нөхцөлд

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

- 3.4.1. Тусгай зөвшөөрөл хүсэгч хүсэлт гаргасал
- 3.4.2. Хуулийн этгээд татан буугдсан
- 3.4.3. Тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон
- 3.4.4. Хууль дүрэмд зааснаас өөр үйл ажиллагааг явуулсан буюу хууль тогтоомжийг нонтой зөрчсөн
- 3.4.5. Зөвшөөрлийг бусдал шилжүүлсэн, мэргэжлийн бус хүн болон зөвшөөрөлд нэр заагдаагүй мэргэжилтнүүд ажиллуулсан нь хяналт шалгалтаар илэрсэн
- 3.4.6. Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтаар удаа дараа эмнэлэг үйлчилгээний зөрчил гаргаж торгууль, шийцэл хүлээсэн, ажиллуулахыг татгалзсан шийдвэр гарсан бол
- 3.4.7. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг аршгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй 6 сар болсон

- 3.4.8. Мэргэжлийн алдаа гаргасан, зөвшөөрөгдөөгүй тусламж, үйлчилгээ явуулж, иргэдийг хохироож чирэгдүүлсэн, үүсгэн байгуулагч, ажиллагсад нь мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг зөрчин арга хэмжээ авалдсан бол
- 3.4.9. Мэргэжлийн аттестатчиллын шалгалтанд хангалтгүй дүн үзүүлсэн
- 3.4.10. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсаас хойш 6 сарын дотор, уг үйл ажиллагааг явуулж эхлээгүй буюу үйл ажиллагаа нь мөн хугацаагаар тасалдсан бол
- 3.4.11. Тусгай зөвшөөрлийг олгосон эрх бүхий байгууллага нь хүчингүй болгосон шийдвэрийн талаар харъяалах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.



Нийслэлийн Засаг даргын 2002 оны захирамжийн гуравдугаар хавсрагт

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

- 1.1. Энэхүү журмыг өмчийн аль ч хэлбэрийн байгууллагад Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход дагаж мөрдөнө.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох Нийслэлийн комисс нь тусгай зөвшөөрөл олгохдоо "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн зарчмыг баримтлан ажиллана.

Тусгай зөвшөөрөл олгох "НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ТӨВ" "Нэг цэгийн үйлчилгээний төв" нь хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- 1. Үйлчилгээний хэсэг
- 2. Зөвшөөрлийн хэсэг

1. Үйлчилгээний хэсэг

Энэ хэсэг нь 3 хүний орон тоотой (хувийн эмнэлэг, эмийн сан харуусан мэргэжилтэн, хуулийн зөвлөх) байх ба холбогдолтой мэдээлэл, мэргэжлийн зөвлөлгөө өгнө. Тус хэсэг нь дор дурьдсан үйлчилгээ явуулна. Үүнд:

- ◆ Тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлаар мэргэжлийн зөвлөлгөө өгөх
- ◆ Шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх
- ◆ Хууль эрх зүйн мэдээлэл зөвлөлгөө өгөх
- ◆ Үйлдвэрлэл үйлчилгээ явуулах байр, орон сууц, ажлын байрны талаар тодорхой мэдээллээр хангах
- ◆ Холбогдох байгууллагын мэргэжилтнүүд зөвлөлгөө өгч тухайн байгууллагатай холбоотой зөвшөөрөл авахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх

Тус хэсэгт Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс гадна доорх байгууллагын мэргэжилтнүүд байна. Үүнд:

- ◆ Улсын бүртгэлийн алба
- ◆ ОМУХАлба
- ◆ Нийслэлийн ЭМХА
- ◆ Төрийн өмчийн газар
- ◆ Хотын өмчийн газар
- ◆ Наториатын газар
- ◆ Стандарт хэмжил зүйн газар
- ◆ Хөрөнгийн үнлэгээний газар дүрмийн санд орох тоног төхөөрөмжийг баталгаажуулна

Дээр дурьдсан байгууллагуудын мэргэжилтнүүд нь ажлын 1 хоногт 09.00-13.00 цаг хүртэл Нийслэлийн Эрүүл мэндийн газар дээр ажиллаж, холбогдох чиглэлээр зөвлөлгөө өгөхөөс гадна өөрсдийн байгууллагатай холбоотой зөвшөөрөл авахад шаардлагатай дүгнэлтүүдийг гаргаж өгнө.

Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримт

- ◆ Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл
- ◆ Тусгай зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ
- ◆ Иргэний үнэмлэхний нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар
- ◆ Эрүүл мэндийн байгууллагын дүрэм, журам (биталгаажсан)
- ◆ Эмч ажилчдын анкет, үнэмлэх дипломын хуулбар, эмчлэх, сувилах лиценз
- ◆ Барилга байгууламжийн баталгаа, гэрээ
- ◆ Эрүүл мэндийн улсын хяналтын алба, Нийслэлийн эрүүл мэндийн хяналтын албаны дүгнэлт
- ◆ Дүрмийн сангийн бүрдүүлэлт, түүний аюулгүй ажиллагааны баталгаа
- ◆ Санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа

2. Зөвшөөрлийн хэсэг

Эшэ хэсэг нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба сард 1 удаа тодорхой цагт хуралдаж, аж ахуйн нэгж байгуулж хувийн эмцэлэг, эмийн сан ажиллуулахад шаардагдах бүхий л бичиг баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн хүмүүст доорх үйлчилгээг үзүүнэ. Үүнд:

- ◆ Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн эрх олгоно
- ◆ Эрх авсан байгууллага Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт, үнэт цаас гэрчилгээний үнэ төлсөн баримтаа авчирч, тусгай зөвшөөрлийн гэрчилгээгээ бичүүлж авна.
- ◆ Шинээр тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгоно
- ◆ Гэрчилгээний нэмэлт, өөрчлөлт хийнэ

Тус хэсэгт доорх хүмүүс оролцоно.

- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга
- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн газрын эмцэлэг үйлчилгээний хэлтсийн дарга
- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн газрын уламжлалт анагаах ухаан, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын асуудал хариусан мэргэжилтэн
- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн хяналтын албаны дарга
- ◆ Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга
- ◆ Нийслэлийн нийгмийн даатгалын газрын эрүүл мэндийн даатгалын асуудал хариуцсан тасгийн дарга
- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ◆ Нийслэлийн өмчийн харилцааны газрын дарга
- ◆ Нийслэлийн эм, биобэлдмэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
- ◆ Нийслэлийн эрүүл мэндийн газрын дүн бүртгэлийн мэргэжилтэн

1.3. Хувийн эмцэлгүүдэд сонгогч шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгохоос гадна хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын талаар баримтлах бодлого чиглэлийг үндэслэл болгоно.

1.4. Аж ахуйн үйл ажиллагааг зөвхөн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасан путаг дэвсгэрт тогтоосон хугацаа, нөхцөлд явуулна.

1.5. Эрүүл мэндийн байгууллагын үүсгэн байгуулагч нь мэргэжлийн үйл ажиллагаа явуулах чиглэл өөрчлөгдөх бүрт зөвшөөрлийн гэрчилгээнд нэмэлт хийлгэнэ.

1.6. Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

- 1.7. Нийслэлийн онцлог байдлаас шалтгаалж сонгон шалгаруулалтын журмаар комисс нь холбогдох материалыг хүлээн авснаас хойш сард нэг удаа хуралдаж шийдвэрлэнэ.
- 1.8. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан бол үндэслэлийг зааж бичгээр харну өгнө.
- 1.9. Тусгай зөвшөөрөл авахад Эрүүл мэндийн хуулийн 12 дугаар зүйл, сайдын 100 дугаар тушаалаар батлагдсан баримт бичгийг бүрдүүлнэ.
- 1.10. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох Нийслэлийн комиссын дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.
- 1.11. Комисс нь эрх хэмжээнийхээ хүрээнд тусгай зөвшөөрөл олгоно, бүртгэнэ, гүдгэлзүүлнэ, сэргээнэ, сунгана, хүчингүй болгоно. (хяналт тавих асуудлыг Эрүүл мэндийн хяналтын албадаар гүйцэтгүүлнэ)
- 1.12. Тусгай зөвшөөрлийг зөрчлийн улмаас хаах бол Эрүүл мэндийн хяналтын албаны гаргасан акт, хуульд заасан хугацаагаар үйл ажиллагаа явуулаагүй, тайлан мэдээ өгөөгүй бол дүн бүртгэлийн болон хувийн эмнэлэг харилцсан мэргэжилтний саналыг үндэслэн Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын даргын тушаал гарснаар хүчингүй болсонд тооцно.
- 1.13. Тусгай зөвшөөрлийг алх 1 жил хүргэлх хугацаагаар олгож, 3 жилээр сунгалт хийнэ. Онцгой тохиолдолд шаардлагатай гэж үзвэл 1 жилээр олгож, сунгаж болно.
- 1.14. Комисс нь тамга тэмдэг, тушаал, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.
- 1.15. Хураах хураамж
 - ◆ Тусгай зөвшөөрлийн үнэ 12500 төгрөг
 - ◆ Гэрчилгээний үнэ 6000 төгрөг
 - ◆ Гэрчилгээний сунгалтын үнэ 3000 төгрөг
- 1.16. Хураамжийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Улсын татварын албад гаргаж өгнө.
- 1.17. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоо
 - 1.17.1. Хэвтүүлэн эмчлэх ор бүхий хувийн эмнэлэг
 - 1.17.2. Эмчилгээ оношлогооны төв
 - 1.17.3. Амбулаторын үйлчилгээ
- 1. Хэвтүүлэн эмчлэх ор бүхий эмнэлэг
 - ◆ ЭМБ –д мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комиссоос зөвшөөрөл олгоно.
 - ◆ Эрүүл мэндийн улсын хяналтын алба дүгнэлт гаргаж, байнгын хяналт тавина
- 2. Эмчилгээ оношлогооны төв
 - ◆ ЭМБ-д мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комиссоос зөвшөөрөл олгоно.
 - ◆ Шинээр тусгай зөвшөөрөл авах үед Нийслэлийн эрүүл мэндийн хяналтын алба дүгнэлт гаргана
 - ◆ Сунгалт хийгэх үед болон байнгын хяналтыг дүүргийн эрүүл мэндийн хяналтын алба хийнэ.
- 3. Амбулаторийн үйлчилгээ
 - ◆ ЭМБ-д мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох нийслэлийн комиссоос зөвшөөрөл олгоно.

- ◆ Шинээр тусгай зөвшөөрөл авах үед Нийслэлийн эрүүл мэндийн хяналтын алба дүгнэлт гаргана
- ◆ Сунгалт хийлгэх үед болон байнгын хяналтыг дүүргийн эрүүл мэндийн хяналтын алба хийнэ.